

Төрийн үйлчилгээний вэб портал www.e-mongolia.mn-ийн үйлчилгээний нөхцөл

E-mongolia.mn нь Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын эрхлэн ажиллуулдаг төрийн үйлчилгээг өөртөө нэгтгэсэн вэб портал систем юм.

Та системд нэвтэрснээр Үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч төрийн үйлчилгээг цахимаар авах боломжтой болно.

Нэг. Нэр томъёоны тодорхойлолт

- 1.1. “E-mongolia.mn” нь төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжтой вэб портал систем юм.
- 1.2. “Гишүүн байгууллага” гэж e-mongolia.mn порталд нэгтгэсэн төрийн үйлчилгээг цахимаар үзүүлж буй эрх бүхий төрийн байгууллага юм.
- 1.3. “ДАН” нь цахим орчинд тухайн иргэнийг таньж, баталгаажуулах зорилготой, өөр хоорондоо харилцан хамааралгүй системүүдтэй ажиллах боломжтой платформ бүхий танилт нэвтрэлтийн нэгдсэн систем юм.
- 1.4. “ХУР” нь олон улсын жишигт нийцсэн, найдвартай ажиллагаатай, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэхэд зориулсан төрийн мэдээлэл солилцооны систем юм.

Хоёр. E-mongolia.mn системийн үйлчлүүлэгч

- 2.1. Монгол Улсын иргэн (зарим үйлчилгээнд насны хязгаар тогтоож болно);
- 2.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн (Монгол Улсад оршин суух үнэмлэх авсан, хурууны хээний мэдээллийг өгсөн байх шаардлагатай);
- 2.3. Аж ахуйн нэгж, байгууллага түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд.

Гурав. E-mongolia.mn-д нэвтрэх

- 3.1. Үйлчлүүлэгч www.e-mongolia.mn-д дараах байдлаар нэвтрэх боломжтой. Үүнд:
 - ✓ тоон гарын үсэг,
 - ✓ цахим орчинд иргэнийг таньж баталгаажуулах “ДАН” систем,
 - ✓ интернэт банкны эрх,
 - ✓ бусад.
- 3.2. ДАН системд ашиглагдах үйлчлүүлэгчийн регистрийн дугаар, нууц үг, тоон гарын үсгийн гэрчилгээ, гар утас руу мессежээр илгээдэг нэг удаагийн нууц кодын аюулгүй байдлыг хэрэглэгч хариуцна.
- 3.3. Үйлчлүүлэгч өөрийн бүртгэл, хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс үйлчилгээ авч дууссан бол системээс гарах шаардлагатай. Үйлчлүүлэгчийн

өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж түүний хувийн болон бусад мэдээллийн аюулгүй байдалд учирсан аливаа эрсдэл, хохирлыг e-mongolia.mn хариуцахгүй.

3.4. E-mongolia.mn -нд робот, бот, програм хангамж ашиглан нэвтрэх, бүртгүүлэхийг хориглоно.

3.5. E-mongolia.mn -д өөр үйлчлүүлэгчийн нэвтрэх эрхийг ашиглаж үйлчилгээ авахыг хориглоно.

3.6. E-mongolia.mn -д нэвтрэх эрх, нууц үг, тоон гарын үсгийн токен зэргийг бусдад хууль бус зорилгоор дамжуулах, ашиглуулахыг хориглоно.

3.7. Үйлчлүүлэгч e-mongolia.mn -д нэвтрэх эрхээ бусдад алдсан, шилжүүлсэн эсхүл зөвшөөрөлгүй таны хувийн мэдээлэлд хандсан нөхцөл байдал үүссэн гэж үзвэл энэ тухай хуулийн байгууллагад мэдэгдэж, нууц үгээ солих үүрэгтэй.

Дөрөв. Хувийн өгөгдөл, мэдээлэл

4.1. E-mongolia.mn -д “ДАН” систем болон интернэт банкны эрхийг ашиглан нэвтэрснээр тухайн үйлчилгээнд ашиглагдах Таны хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, эрх бүхий төрийн байгууллагад шилжүүлэхийг зөвшөөрнө.

4.2. ХУР системээр дамжуулан үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэлд хандсан байдал, үйлчилгээний түүх, идэвхтэй байгаа үйлчилгээний хүсэлт шийдвэрлэлтийн байдал, төлбөрийн мэдээлэл зэргийг үйлчлүүлэгч өөрөө шалгах боломжийг e-mongolia.mn бүрдүүлнэ.

4.3. Үйлчлүүлэгч e-mongolia.mn, ХУР системээс гарч байгаа мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, зөрүүтэй, алдаатай мэдээллийн талаар e-mongolia.mn болон эрх бүхий төрийн байгууллагад мэдэгдэж залруулах талаар шаардлага тавих эрхтэй.

4.4. Үйлчлүүлэгчийн алдаатай, дутуу, буруу оруулсан дата мэдээллээс шалтгаалан эрх бүхий гишүүн байгууллага үйлчилгээний хүсэлтийг буцаасан, үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан, үйлчилгээ үзүүлэх хугацаа удааширсан гэх мэт аливаа үр дагавар үүссэн нөхцөлд e-mongolia.mn хариуцлага хүлээхгүй.

4.5. Үйлчлүүлэгчийн нэвтрэх эрхийг цуцлах, түр хугацаанд хаах нь тухайн үйлчлүүлэгчийн системд үүссэн дата, мэдээллийг устгах үндэслэл болохгүй.

4.6. E-mongolia.mn -д үүссэн үйлчлүүлэгчийн дата мэдээллийг өөрийнх нь албан ёсны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр арилжаа, зар сурталчилгааны зорилгоор ашиглахыг хориглоно.

4.7. Үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэл, үйлчилгээний хүсэлттэй холбоотой цахим баримт бичиг, дата мэдээллийг хууль тогтоомжийн дагуу цахим архив үүсгэн хадгална.

4.8. E-mongolia.mn -тэй холбоотой техник, технологи, хадгалагдаж буй бүх мэдээлэл нь E-mongolia.mn -ийн дата бөгөөд Монгол Улсын “Байгууллагын нууцын тухай”, “Төрийн болон албаны нууцын тухай”, “Хувь хүний нууцын тухай” хуулиар зохицуулагдана.

Тав. Хэрэглэгчийн эрх

- 5.1. Үйлчлүүлэгч өөрийн хувийн мэдээллийг e-mongolia.mn хэрхэн ашиглаж байгаа талаар мэдээлэл гаргуулж авах эрхтэй.
- 5.2. Үйлчлүүлэгч e-mongolia.mn -ийг ашиглахаас татгалзах, нэвтрэх эрхээ хаалгах эрхтэй.
- 5.3. Үйлчлүүлэгч e-mongolia.mn порталаар гаргасан үйлчилгээний хүсэлтийн хэрэгжилт, үр дүнгийн талаар мэдээлэл авах эрхтэй.
- 5.4. Үйлчилгээний нууцлал, аюулгүй байдал, найдвартай ажиллагааны талаар санал, гомдлыг гишүүн байгууллагад хандан гаргах эрхтэй.

Зургаа. E-mongolia.mn -ийн эрх, үүрэг

- 6.1. Үйлчлүүлэгч энэхүү нөхцөлөөр тогтоосон үүргийг биелүүлээгүй тохиолдолд e-mongolia.mn -д нэвтрэх эрхийг цуцлах, түр хугацаагаар хаах эрхтэй. Шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад мэдээлнэ.
- 6.2. E-mongolia.mn -ийн хөгжүүлэлт, найдвартай ажиллагаа, үйлчилгээнд ашиглагдсан үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийн найдвартай байдлыг хангах үүрэгтэй.
- 6.3. Гишүүн байгууллагатай хамтран төрийн үйлчилгээний талаар үнэн зөв, цэгцтэй мэдээллийг үйлчлүүлэгчид өгөх үүрэгтэй.

Долоо. Мэдэгдэл (Notification)

- 7.1. E-mongolia.mn-ээр гаргасан үйлчилгээний хүсэлт, төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын явц, үр дүнгийн талаар мэдээллийг e-mongolia.mn -ний үйлчлүүлэгчийн мэдэгдэл буланд харуулна.
- 7.2. Үйлчилгээний хүсэлт, өргөдөл, гомдлын талаар танд ирүүлсэн мэдэгдлийг тухай бүр унших нь Үйлчлүүлэгчийн үүрэг байна.
- 7.3. Хэрэв өөр хүнд хаягласан мэдэгдлийг хүлээж авсан бол энэ талаар e-mongolia.mn -д мэдэгдэх шаардлагай.
- 7.4 Үйлчилгээний хүсэлт шийдвэрлэлийн талаарх мэдээллийг иргэн өөрийн гар утсанд мессеж байдлаар авах хүсэлт гаргаж болно.
- 7.5 Үйлчилгээний хүсэлт шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг иргэн өөрийн хувийн имэйлээр авах хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд үйлчлүүлэгчийн хувийн имэйлээр илгээнэ.

Найм. Сэжигтэй тохиолдолд нэн даруй мэдэгдэх

Хэрэв таны e-mongolia.mn бүртгэлээр өөр этгээд нэвтэрч байгаа талаар ямар нэг сэжиг төрвөл энэ талаар бидэнд нэн даруй мэдэгдэнэ үү.
Холбоо барих хаяг: Ш/х-785, Төв шуудан, Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг, УБ 15160-0026 e-mongolia@cita.gov.mn

Ёс. Хууль зөрчсөн хэрэглээ (үйлдэл)

9.1. E-mongolia.mn үйлчилгээний нэгдсэн порталыг дараахь зорилгоор ашиглаж болохгүй. Үүнд:

- 9.1.1. хууль зөрчсөн, залилан мэхэлсэн шинжтэй аливаа үйлдэл;
- 9.1.2. хуурамч баримт бичиг ашиглан үйлчилгээний хүсэлт илгээх, үйлчилгээ авахыг завдах;
- 9.1.3. E-mongolia.mn болон түүний дэд системүүдэд халдах, хакердах, системд гэмтэл, саатал учруулах, доголдуулах;
- 9.1.4. бусад үйлчлүүлэгчийн эрхийг зөрчих, e-mongolia.mn ашиглахад нь саад учруулах;
- 9.1.5. хууль зөрчсөн, зөрчихийг уриалсан агуулгатай материалыг нийтлэх, илгээх.

Арав. Гишүүн байгууллагын үйлчилгээний нөхцөл

- 10.1. Гишүүн байгууллагын цахим үйлчилгээ тус бүр хууль тогтоомж, үйлчилгээний онцлогоос хамааран “Үйлчилгээний тусгай нөхцөл”-тэй байж болно.
- 10.2. Үйлчлүүлэгч Гишүүн байгууллагын үйлчилгээний тусгай нөхцөлтэй танилцаж, дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.
- 10.3. Гишүүн байгууллагаас үйлчилгээний хүсэлтийг шийдвэрлэсэн байдалд e-mongolia.mn хариуцлага хүлээхгүй.

Арван нэг. E-mongolia.mn системийн зохиогчийн эрх

- 11.1. Албан ёсоор бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд e-mongolia.mn болон түүний агуулгыг хуулбарлах, дуурайлгах, бусад програм хангамж ашиглан нэвтрэхийг хориглоно.
- 11.2. E-mongolia.mn -ний нэр, лого, ажиллах зарчим, эх код, өгөгдлийн бүтэц зохиогчийн эрхээр хамгаалагдана.

Арван хоёр. Үйлчилгээний төлбөр тооцоо

- 12.1. E-mongolia.mn нь үйлчилгээний хүсэлт биелсний дараа төлбөрийн мэдэгдлийг Төрийн цахим үйлчилгээний порталаар хүргэнэ.
- 12.2. E-mongolia.mn төлбөр төлөх олон боломжийг үйлчлүүлэгчид санал болгох ба тухайн төлбөр тооцооны хэлбэрээс хамаарч гүйлгээний шимтгэл харилцан адилгүй байна.
- 12.3. Үйлчлүүлэгч болон төлбөр тооцооны хэрэслийг санал болгож буй байгууллагын хооронд үүсэх гүйлгээний шимтгэлтэй холбоотой аливаа асуудлыг e-mongolia.mn хариуцахгүй.
- 12.4. Үйлчилгээний үр дүнг хүлээн авахдаа шуудан хүргэлтийн үйлчилгээ авах тохиолдолд холбогдох зардлыг үйлчлүүлэгч хариуцна.

Арван гурав. E-mongolia.mn -ний ашиглалт, үйлчилгээ

- 13.1. E-mongolia.mn нь 7 хоногийн бүх өдөр 24 цагийн горимоор ажиллана.

13.2. E-mongolia.mn нь төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийх зорилгоор хэсэгчлэн болон бүрэн хэмжээнд түр зогсолт хийж болно. Засвар үйлчилгээний талаарх мэдээллийг ажлын 2 хоногийн өмнө нийтэлж байна.

13.3. E-mongolia.mn нь бүх нийтийн амралтын өдрүүдэд ажиллах хэдий ч гишүүн байгууллагын үйлчилгээний хүсэлтийг боловсруулах хугацаанд өөрчлөлт орж болно.

13.4. Гишүүн байгууллагын мэдээллийн системд гарсан доголдолд e-mongolia.mn хариуцлага хүлээхгүй боловч системийн найдвартай ажиллагааг сэргээхэд хүчин чармайлт гарган ажиллана.

13.5. E-mongolia.mn дээрх цахим үйлчилгээ тус бүрийн талаар үйлчлүүлэгчид аль болох цогц мэдээлэл өгөхийг эрмэлзэнэ.

13.6. Үйлчлүүлэгч нь e-mongolia.mn -ийг ашиглах тухай 11-11 тусгай дугаараас мэдээлэл авч болох ба үйлчлүүлэгчийн байгаа байрлалд биечлэн очиж тусламж, дэмжлэг үзүүлэхгүй.

13.7. E-mongolia.mn-ийн алдаанаас болж үйлчлүүлэгч, гишүүн байгууллагад учирсан аливаа хохирлыг шалгах техникийн багийг байгуулах ба түүний дүгнэлтэд үндэслэн асуудлыг шийдвэрлэнэ.

Арван дөрөв. Бусад

14.1. Үйлчлүүлэгч нь e-mongolia.mn -ийг ашиглахтай холбоотой гарын авлагыг E-mongolia.mn портал сайтаас авах боломжтой байна.

14.2. Үйлчлүүлэгчээс ирүүлсэн санал, гомдол, хүсэлтийг e-mongolia.mn -ий өргөдөл, гомдол цэсээр, 11-11 утсаар эсхүл үйлчилгээний нэгдсэн төвөөр (ажлын өдрүүдэд 08:30 - 17:30 цагийн хооронд) хүлээн авч шийдвэрлэнэ.

14.3. Үйлчилгээний тасалдал нь байгалийн давагдашгүй хүчин зүйл (гал, үер, газар хөдлөлт, аянга болон тэсрэлт) эсвэл төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан хуулийн зохицуулалт, журам, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, ажил хаялт, дайн, террорист халдлага, гоц халдварт өвчин зэрэгтэй холбоотой бол Үйлчилгээг тасалдсанд тооцохгүй бөгөөд e-mongolia.mn нь хариуцлага хүлээх үндэслэл болохгүй.

14.4. Үйлчлүүлэгч нь Үйлчилгээний нөхцөлөөр хүлээсэн үүргээ зөрчсөн, Үйлчилгээг хууль бусаар ашигласан, Үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд болон бусад үйлчлүүлэгчид хохирол учруулсан нь батлагдвал Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

14.5. Эрх бүхий төрийн байгууллага үйлчлүүлэгчийн мэдээлэлтэй хуулийн дагуу танилцах эрхтэй байна.

14.6. Үйлчилгээтэй холбоотой санал, гомдол, асуудал, маргааныг Талууд эв зүйгээр харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Хэрэв шийдвэрлэх боломжгүй бол Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.